

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2009 оны 6 дугаар
сарын 8

Дугаар 170

Улаанбаатар

Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний болон удирдах албан тушаалд томилогдох ажилтны эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журмыг шинэчлэн батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 49.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний болон удирдах албан тушаалд томилогдох ажилтны эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг нэгдүгээр, “Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний болон удирдах албан тушаалд томилогдох ажилтны эрүүл мэндийн хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Уг тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2007 оны 133 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД

С.ЛАМБАА

**ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНД АНХ ОРОХ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТАНД
ТЭНЦСЭН ИРГЭНИЙ БОЛОН УДИРДАХ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДЛЫГ
ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний болон удирдах албан тушаалд томилогдох ажилтны эрүүл мэндийн байдлыг тодорхойлж дүгнэлт гаргахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Эрүүл мэндийн үзлэгийн зохион байгуулалт

1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний болон удирдах албан тушаалд томилогдох ажилтны эрүүл мэндийн үзлэгийг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулна.
2. Төрийн албаны зөвлөл нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран яам, агентлагт ажиллахаар Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний болон удирдах албан тушаалд томилогдох ажилтны эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллага, үзлэг хийх хугацааг сонгон мэдээлнэ.
3. Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран нийслэл, дүүргийн түвшинд ажиллахаар Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний болон удирдах албан тушаалд томилогдох ажилтны эрүүл мэндийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гаргах магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллага, үзлэг хийх хугацааг сонгон мэдээлнэ.
4. Аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь аймаг, сумын түвшинд ажиллахаар Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэний болон удирдах албан тушаалд томилогдох ажилтны эрүүл мэндийн байдлыг аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн эмч нарын үзлэгээр тодорхойлж, дүгнэлт гаргуулна.

Гурав. Эрүүл мэндийн үзлэг

1. Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэн болон удирдах албан тушаалд томилогдох ажилтан нь Төрийн албаны зөвлөл, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас заасан эмнэлэгт тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэгт орно.
2. Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэнийг болон удирдах албан тушаалд томилогдох ажилтныг Эрүүл мэндийн хуудсанд бичигдсэн бүх төрлийн үзлэгийг хийлгэсний дараа эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга буюу амбулаторийн эрхлэгч нь тухайн иргэнийг Төрийн жинхэнэ албанд томилогдон ажиллахад эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэх талаар дүгнэлт гаргаж, гарын үсэг зурж баталгаажуулна.
3. Эрүүл мэндийн хувьд Төрийн жинхэнэ албанд ажиллахад тэнцэхгүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тухайн иргэн эмнэлгийн үзлэг, дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа, түүнчлэн эрүүл мэндийн үзлэгтэй холбоотой бусад асуудлаар холбогдох хууль, журамд заасны дагуу санал, хүсэлт, гомдлоо Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлд хандан шийдвэрлүүлнэ.

Дөрөв. Эрүүл мэндийн үзлэгийн төлбөр

Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэн болон удирдах албан тушаалд томилогдох ажилтан нь эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг тухайн магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн даргын баталсан тарифын дагуу төлнө.

Тав. Бусад

1. Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэнд болон удирдах албан тушаалд томилогдох ажилтанд үзлэг хийж байгаа хүний их эмч, дүгнэлт гарган баталгаажуулж байгаа эмнэлгийн удирдах ажилтан нь “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”-г чанд мөрдөж ажиллана.
2. Төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэн болон удирдах албан тушаалд томилогдох ажилтан нь Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн тогтоосноос өөр эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт орсон, хуурамч эсвэл албан ёсоор гарын үсэг зурж баталгаажуулах ёстой эмнэлгийн удирдах ажилтнаас өөр албан тушаалтны гарын үсэг зурагдсан зэрэг тохиолдлуудад тухайн иргэний Эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг хүчингүйд тооцно.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 170 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

**ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНД АНХ ОРОХ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТАНД ТЭНЦСЭН
ИРГЭНИЙ БОЛОН УДИРДАХ АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ АЖИЛТНЫ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ХУУДАС**


Дугаар.....

Эрүүл мэндийн хуудас олгосон:он сарөдөр

Эцэг (эх)-ийн нэр.....

Нэр.....

Нас: Хүйс:.....



№	Үзлэг	Онош	Зөвлөгөө	Он, сар, өдөр	Эмчийн гарын үсэг
1.	Сэтгэц				
2.	Сонсгол				
3.	Хараа				
4.	Дотор				
5.	Сүрьеэ (флюорография эсвэл цээж рентгенд харах)				

Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга (Амбулаторийн эрхлэгч)-ын тухайн иргэнийг Төрийн жинхэнэ албанд ажиллахад эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэх тухай **дүгнэлт**:

.....
.....

Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

(Амбулаторийн эрхлэгч): /

(Гарын үсэг)

(Нэр)

..... оныдугаар сарын-ны өдөр